



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/533

Номгон

Насан туршийн боловсролын төвийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 дахь заалт, 29.3 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2, 30 дугаар зүйлийн 30.1.3 дахь заалт, 39 дүгээр зүйлийн 39.6 дахь заалтууд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/242 тоот тушаалаар баталсан “Насан туршийн боловсролын талаар баримтлах чиглэл”-ийн 4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн “Насан туршийн боловсролын төв”-ийг Боловсролын газрын дэргэд байгуулж захиралыг томилон ажлуулахыг Боловсролын газар /Ц.Энхтөр/-т даалгасугай.

2. “Боловсролын газрын дэргэдэх Насан туршийн боловсрол төв”-ийн шинэчилсэн дүрмийг нэгдүгээр, “Насан туршийн боловсролын нэгж”-ийн дүрмийг хоёрдугаар, бүтэц орон тоог гуравдугаар хавсралтаар баталсугай.

3. “Боловсролын газрын дэргэдэх Насан туршийн боловсрол төв”-ийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг жил бүрийн улсын төсөвт тусгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсролын газар, “Боловсролын газрын дэргэдэх Насан туршийн боловсролын төв”-ийн захирал нарт даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Наранбаяр/-т даалгасугай

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын “Насан туршийн боловсролын төв байгуулах тухай” 2010 оны А/207 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Д.МӨНХСАЙХАН

60110229

Аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар
сарын 25-ны өдрийн А/533 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт



БАЯНХОНГОР АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмээр аймгийн Насан туршийн боловсролын төв (цаашид "төв" гэх) – ийн үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Төв нь: Иргэдийн боловсролын эрэлт хэрэгцээнд тулгуурласан амьдралын чанарыг дээшлүүлэх зорилгоор орон нутгийн хүн амд тасралтгүй боловсролын үйлчилгээ үзүүлэх, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах, хувь хүний хөгжил, ур чадварыг дэмжих, хөгжүүлэх зорилго бүхий сургалт-менежментийн байгууллага мөн.

1.3. Насан туршийн боловсролын төвийн багш, менежер, орон нутгийн нэгжийн багш нарыг мэргэжил, арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

1.4. Төв нь: Үйл ажиллагаандаа Монгол улсын үндсэн хууль, Боловсролын тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийг мөрдлөг болгоно.

1.5. Төв нь: Энэхүү дүрмийг үндэслэн боловсруулсан байгууллагын дотоод журмаар өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулна.

1.6. Төв нь: Бие даасан хуулийн этгээд байх бөгөөд зохих журмын дагуу үйлдсэн тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх ба банкинд харилцах данстай байна.

1.7. Төв нь: Үйл ажиллагааны чиглэл, орон нутгийн онцлогийг харуулсан бэлгэдэлтэй байж болно.

Хоёр. Төвийн үйл ажиллагааны зарчим

2.1. Төв нь: Хүмүүнлэг, Ардчилсан, Тэгш хамруулах ба Насан туршийн суралцахууд тулгуурлаж, шинжлэх ухааны ёс зүй, шударга ёс, бүтээлч хандлага, ил тод байдлыг удирдлага болгон ажиллана.

2.2. Төв нь: Үйл ажиллагааны хувьд байнгын, нээлттэй, хүртээмжтэй байна.

2.3. Төв нь: Боловсролын чиглэлээр төрөөс баталсан эрх зүйн баримт бичгийн хүрээнд стратегийн болон бодлогын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажиллана.

2.4. Үйл ажиллагааны чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг бүтээгдэхүүн хэлбэрээр тухайн шатны засаг даргад нийлүүлж, улсын төсвөөс санхүүжилт авна.

Гурав. Төвийн удирдлага, зохион байгуулалт

3.1. Төвийн бүтэц орон тоо, зохион байгуулалтыг аймгийн Засаг даргын захирамжаар тогтооно.

3.2 Төвийн захирлыг аймгийн Боловсрол соёл урлагийн газрын дарга, бусад ажилтныг төвийн захирал томилж чөлөөлнө.

2.

3.3 Төвийн ажилтан албан хаагчдын ажлын чиг үүрэг, үйл ажиллагааг албан тушаалын тодорхойлолтоор баталгаажуулна.

3.4 Аймгийн Насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагааны тухай жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж ажиллана.

3.4.1 Насан туршийн боловсролын төв нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.4.1.1 Иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх зорилгоор судалгаанд суурилсан бүх нийтийн тасралтгүй боловсролын үйлчилгээг иргэдэд үзүүлнэ.

3.4.1.2 Амьдрах ухаанд суурилсан бичиг үсгийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.4.1.3 Бага, суурь, бүрэн дунд боловсролын боловсрол нөхөн олгох сургалтын хөтөлбөрийн хэрэгжүүлж ажиллана.

3.4.1.4 Мэдээлэл харилцааны технологийг ашигласан зайны сургалтыг өргөжүүлж цахим платформыг хөгжүүлнэ

3.4.1.5 Иргэдийн боловсрол, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, чиглэлээр танхимын ба танхимын бус хэлбэрээр зохион байгуулж зайны сургалтын нэмэлт, туслах материал, гарын авлага, хэрэглэгдэхүүнийг боловсруулж түгээнэ.

3.4.1.6. Төрийн болон орон нутгийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт ажил, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж тайлагнана.

3.4.1.7 Орон нутгийн НТБ-ын нэгжийн үйл ажиллагааг бүхий л талаар дэмжиж мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

3.4.1.8 Бие хүн суралцах чиглэл болон мэргэжлээ сонгох, мэргэжлийн боловсролын замаа сонгох, мэргэжлээ сурч эзэмших улмаар, мэргэжиж хөгжих, мэргэжилтэн болж төлөвшихөд нь сэтгэл зүй, сурган болон нийгмийн туслалцаа дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулна.

3.5. Төвийн дэргэд орон тооны бус мэргэжлийн баг, сонирхлын бүлгэм ажиллаж болно.

Дөрөв. Төвийн эрх, үүрэг

4.1.Төв нь дор дурдсан эрх эдэлнэ.

4.1.1.Насан туршийн боловсролыг хөгжүүлэх чиглэлээр орон нутгийн шинж чанартай хөтөлбөр, арга хэмжээг нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж болно.

4.1.2.Тухайн орон нутгийн ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, соёл, спорт, нутгийн удирдлагын болон захиргааны байгууллагуудын материаллаг баазыг түшиглэн ажиллана.

4.1.3.Олон улсын болон төрийн бус байгууллага, хувь иргэнтэй хамтран хөтөлбөр, төсөл хэрэгжүүлж болно.

3.

4.2. Төв нь дор дурдсан үүрэг хүлээнэ.

4.2.1.Орон нутгийн холбогдох байгууллагууд, иргэдээс насан туршийн боловсролтой холбоотой мэдээ, судалгаа авах, мэдээллийн дата үүсгэх, дүгнэлт хийх, байнга шинэчлэх

4.2.2.Хүн амын боловсролын түвшин, хэрэгцээг судлах, дүгнэлт хийх, тодорхой санал боловсруулан орон нутгийн засаг захиргааны байгууллагаар шийдвэр гаргуулах, хэрэгжүүлэх

4.2.3.Аймгийн насан туршийн боловсролын төв, сумын нэгжийн удирдах ажилтан, багшийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тасралтгүй хөгжлийг хангах ажлыг сургалтын холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах

4.2.4.Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах

4.2.5.Орон нутгаа хөгжүүлэхэд иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах

4.2.6.Холбогдох дээд байгууллагад мэдээ, тайлан гаргаж өгөх, ажлаа тайлагнах

4.2.7.Насан туршийн боловсролын нэгжийн менежер, багш нарын сонгон шалгаруулалтыг явуулах бөгөөд томилох, чөлөөлөхөд санал оруулах, зөвшилцөх

Тав. Төвийн захирлын эрх, үүрэг

5.1. Төвийн захирал дараах эрх эдэлнэ.

5.1.1 Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор хүний нөөц, санхүү, төсвийн талаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн ажиллана.

5.1.2 Төвийн ажилтныг томилох, чөлөөлөх, шагнах, урамшуулах, хариуцлага хүлээлгэнэ.

5.2 Төвийн захирал дараах үүрэг хүлээнэ.

5.2.1 Төвийн боловсон хүчний мэдлэг, ур чадвар, мэргэшлийг дээшлүүлэх, ажлын байр, хөдөлмөр хамгаалал, нийгмийн асуудлын нөхцөлийг сайжруулах талаар арга хэмжээ авч, шийдвэрлэх, тогтвортой, бүтээлч хамт олныг бүрдүүлэх.

5.2.2 Төвийн санхүүжилтийг хууль, тогтоомжид заасан зориулалтын дагуу хуваарилах, захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах.

Зургаа. Төвийн санхүүжилт

6.1. Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

- Улсын төсөв
- Орон нутгийн төсөв
- Төсөл, хандив, тусламж
- Өөрийн үйл ажиллагааны орлого
- Бусад эх үүсвэр


4.

Долоо. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

7.1. Төвийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Насан туршийн боловсролын төв болон аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдлагын зөвлөл шийдвэрлэнэ.

_____оОо_____

Аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын
25-ны өдрийн А/533 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт



СУМЫН НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН НЭГЖИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү дүрмээр сумын Насан туршийн боловсролын нэгж (цаашид “нэгж” гэнэ.)-ийн үйл ажиллагааг зохицуулна. Нэгж нь Насан туршийн боловсролын төв нэртэй байна.

Нэгж нь тухайн орон нутгийн иргэдийн тасралтгүй боловсролын хэрэгцээг тодорхойлох, орон нутаг дахь төрийн болон төрийн бус байгууллага, дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг насан туршийн боловсролын хүрээнд зохицуулах, мэдээллээр хангах, иргэдэд тасралтгүй боловсролын үйлчилгээ үзүүлэх зорилготой боловсролын сургалтын байгууллага мөн.

Хоёр. Нэгжийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Нэгжийг сургууль түшиглэсэн статустай байгуулна.

2.2. Нэгж нь менежер, багшийн орон тоотой ажиллаж болно. Нэгжийн ажилтныг сургуулийн захирал аймгийн Насан туршийн боловсролын төвийн сонгон шалгаруулалт, саналд үндэслэн томилж, чөлөөлнө.

2.3. Нэгжийн дэргэд төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн сонирхлын бүлэг ажиллаж болно.

2.4. Нэгж нь үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, энэхүү үлгэрчилсэн дүрмийг мөрдлөг болгоно.

2.5. Нэгжийн үйл ажиллагаа нээлттэй, хүртээмжтэй, тасралтгүй байна.

Гурав. Нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.1. Тухайн орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагын материаллаг бааз, боловсон хүчний нөөцийг түшиглэж иргэдэд насан туршийн боловсрол олгох хүрээнд хамтран ажиллах

3.2. Орон нутгийн засаг захиргааны байгууллагаас шийдвэр гаргуулах, хэрэгжүүлэх

3.3. Үйл ажиллагааны хүрээнд дотоодын болон олон улсын байгууллага, иргэдтэй хамтран хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх

2.

3.4. Хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, сургалт, судалгаа явуулах замаар санхүүгийн зохих нөөц бүрдүүлж холбогдох хууль, журмын дагуу зохицуулах

3.5. Насан туршийн боловсролын чиглэлээр сургалт-үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагаас холбогдох мэдээ, тайлан гаргуулж авах

3.6. Баг, хорооны Засаг дарга, нийгмийн ажилтануудтай хамтран орон нутгийн холбогдох байгууллага, иргэдээс насан туршийн боловсролын хэрэгцээний судалгаа авах

3.7. Иргэдийн хэрэгцээнд үндэслэн гэр бүл, иргэн, ёс суртахуун-төлөвшил, гоо зүй- мэдрэмж, амьдрах ухааны болон дүйцсэн хөтөлбөрийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг суманд тасралтгүй зохион байгуулах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төр, иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулж зохицуулах

3.8. Орон нутгийн онцлогт тохирсон сургалтын материал, гарын авлага боловсруулан ашиглах

3.9. Үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд аймгийн Боловсролын газар, Насан туршийн боловсролын төвд хүргүүлэх

Дөрөв. Нэгжийн санхүүжилт

4.1. Нэгжийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

- Улсын төсөв
- Орон нутгийн төсөв
- Төсөв, хандив, тусламж
- Өөрийн үйл ажиллагааны орлого
- Бусад эх үүсвэр

4.2. Нэгжийн менежер багш, багшийн цалин хөлс, нийгмийн даатгалын хураамж, томилт, үйл ажиллагааны зардлыг боловсролын төвлөрсөн арга хэмжээний төсөвт, сургалтын танхим болон албан тасалгааны гэрэл, дулаан, усан хангамж, шуудан холбоо, урсгал засвар, үйл ажиллагааны зарим зардлыг орон нутгийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

Аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын
25-ны өдрийн А/БЗЗ дугаар захирамжийн
3 дугаар хавсралт



АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН БҮТЭЦ

